



**ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Орон нутгийн эмнэлгийн байгууллагад эмч томилон
ажиллуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн эмнэлгийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд осол гэмтлийн үеийн яаралтай тусламжийн сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажиллах, осол гэмтлийн тохиолдол ихтэй аймгуудын иргэдэд осол гэмтлийн үеийн яаралтай тусламж болон мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн иргэд үйлчлүүлэгчдэд хамтарсан үзлэг оношилгоо хийн, төрөлжсөн мэргэшлийн арга зүйн зөвлөмж өгч, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллах зорилгоор 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 27-ны хооронд Ховд аймгийн Бүсийн оношилгооны төвд ажиллах эмч нарыг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Багийн ахлагч:
Гишүүд:

С.Баатаржав (ЭШСАлбаны дарга)
Ц.Батбаяр (НХГСТ-н их эмч)
Д.Оюунжаргал (ХГСТ-н их эмч)
Э.Энхтүвшин (ГТГТ-н их эмч)
Б.Мөнхбаяр (Түлэгдлийн эмнэлгийн их эмч)
В.Нямдаваа (Түлэгдлийн эмнэлгийн их эмч)
Д.Энхжаргал (ААХҮАлбаны жолооч)

2. Ховд аймгийн Бүсийн оношилгооны төвд томилолтоор ажиллах удирдамжийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж, ажлын үр дүнг танилцуулахыг багийн ахлагч (С.Баатаржав)-д үүрэг болгосугай.

3. Томилолтоор ажиллах эмч нарын замын болон томилолтын зардлыг батлагдсан төсвөөс гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Ц.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ инновац хариуцсан дэд захирал (Б.Батзориг)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ